



"Билэгт баялаг" ХХК

ДОРНОГОВЬ АЙМГИЙН ДАЛАНЖАРГАЛАН СУМ

“АЛАГТОЛГОД”-ЫН НҮҮРСНИЙ ОРДОД ЗҮҮНДАЛАН, ДАЛАН – MV021008 ТООТ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ЭЗЭМШИГЧИЙН 2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН

ХЯНАСАН:

БОАЖЯ-ны ХБОБНУГ-ын мэргэжилтэн/ Б.Буяннэмэх /

ХЭРЭГЖИЛТИЙГ ГАРГАСАН:

“Билэгт Баялаг” ХХК-ийн захирал/ Э.Энхзаяа /

“Билэгт Баялаг” ХХК-ийн БО-ны мэргэжилтэн /З.Сандагдорж /

АГУУЛГА

ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА.....	1 - 8
ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ.....	9
БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ.....	10
СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ БИЕЛЭЛТ.....	11 - 21
НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ.....	22
ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ.....	23-25
НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ.....	26
ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ.....	26
ХИМИЙН БОДИСЫН ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ.....	27
ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ.....	28-29
УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ.....	30
ОСОЛ, ЭРСДЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ.....	31-33
ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР.....	34-55
ДҮГНЭЛТ.....	56
ХАВСРАЛТУУД.....	58-69

ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

“Билэгт Баялаг” ХХК-ийн байгаль орчныг хамгаалах бодлогын гол зорилго нь Монгол улсын “Ашигт малтмалын тухай хууль”, “Байгаль орчныг хамгаалах тухай хууль” болон байгаль орчинтой холбогдох бусад хууль, дүрэм, журам, компанийн үндсэн бодлогын дагуу явуулахад оршино.

Манай компани нь MV-021008 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий 178.98 га талбай эзэмшдэг бөгөөд 2017 онд хайгуул хийн нөөцөө баталгаажуулж Зүүндалан, Далангийн чулуун нүүрсний ордыг ил аргаар ашиглах ТЭЗҮ-ийг Кэйстоун ХХК боловсруулж 2018 онд батлуулсан.


Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний нэмэлт тодотголын ажлыг “Саут Воли” ХХК 2018 онд боловсруулж БОАЖЯ-аар баталгаажуулсан байна. Байгаль орчны аудитын ажлыг эрх бүхий “Грийн сервис” ХХК 2021 онд хийж гүйцэтгэсэн.

Энэхүү биелэлтийн тайланг боловсруулахдаа “Байгаль орчныг хамгаалах тухай”, “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай” болон бусад холбогдох эрх зүйн баримтууд, БОНХЯ-ны сайдын 2014 оны 01-р сарын 06-ны өдрийн А-05 тоот тушаалаар батлагдсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам” зэргийг удирдлага болголоо.

Төсөл хэрэгжиж буй газрын засаг захиргааны харьяалал

Зүүндалан, Далангийн нүүрсний орд нь засаг захиргааны хуваарлалтаар Дорноговь аймгийн Даланжаргалан сумын Элдэв багийн нутагт Улаанбаатар хотоос зүүн урагш 270 км, Дорноговь аймгийн төв

Сайншанд хотоос баруун хойш 200 км, Даланжаргалан сумын төвөөс баруун хойш 28 км, төмөр замын 25-р зөрлөг болон Улаанбаатар-Сайншандыг холбосон автозамаас 22 км зайд байрлах “Баруундалан” хэмээх газрын зүүн хэсэгт орших ба физик газарзүйн мужлалаар тал хээргөвийн бүст хамаарна. Уг орд нь дэд бүтэц зам харилцаа сайн хөгжсөн, цахилгаан эрчим хүчний төвийн шугам сүлжээнд холбогдсон бүс нутагт оршино.



Зүүндалан, Далан тусгай зөвшөөрөлтэй талбайн солбилцол

Цэгийн дугаар	Урграг			Өргөрөг		
	Град	Мин	Сек	Град	Мин	Сек
1	108	58	1.63	46	8	11.66
2	108	58	1.63	46	7	51.66
3	108	58	21.62	46	7	51.66
4	108	58	21.62	46	7	31.65
5	108	56	41.63	46	7	31.65
6	108	56	41.63	46	7	51.66
7	108	57	26.62	46	7	51.66
8	108	57	26.62	46	8	11.66

Дэд бүтэц, зам харилцаа

УБ хотоос төмөр замын 25-р зөрлөг хүртэл хатуу хучилттай замаар зорчино. Цааш уурхайн талбай хүртэл автомашинаар зорчихдоо бартаа саадгүй сайжруулсан шороон замын сүлжээтэй.

Уурхайн карьер, хөрсний овоолго, кемп, засварын газрууд нь хоорондоо шороон замаар холбогдсон. Уурхайгаас “МАК” ХХК-ийн сайжруулсан нүүрс тээврийн зам хүртэлх замын даланг уурхайн хөрс хуулалтаас гарсан хөрсөөр хийсэн ба технологийн тээврийн зам нь 20 м өргөнтэй нийт 1.4 км замын суурь нь 0.45 м зузаан, 0,25 метр хайрган хучилттай бөгөөд цаг агаарын байдалд тэсвэртэй, ус урсах боломжтой 100 хүртэл тонны даацтай тээврийн хэрэгслүүд явахад зориулагдсан. Харилцаа холбооны хувьд үүрэн телефоны оператор компаниудын сүлжээ нэвтэрсэн.

Геологийн тогтоц

Алагтогоогийн чулуун нүүрсний ордыг агуулж буй грабен хэлбэрийн хотос структур нь хожуу мезозойн ревивацийн нөлөөллөөр үүссэн бөгөөд говийн атриат бүсэд хамаарагдана. Энд дээд юрадоод цэрдийн Цагаанцав формацийн бялхмал-тунамал хурдас, доод цэрдийн туфоген-тунамал хурдас, дөрөвдөгчийн эх газрын тунамал хурдас тархсан байдаг.

Физик газарзүй

Уурхайн талбай нь намхан толгод зонхилсон тал хээрийн бүсэд багтах бөгөөд хамгийн өндөр цэг нь уурхайн талбайгаас зүүн хойш 3.7 км-т байрлах 1352.2 тоот өндөрлөг бол нам доор цэг нь уурхайн талбайгаас баруун тийш 7 км-т байрлах Бэхтийн-Улаан нуур /1179.6 м/ юм. Харьцангуй өндөржилт нь 50 м-с хэтрэхгүй.

Байгаль цаг уурын нөхцөл

Ордын талбайн орчин тойрон нь эх газрын эрс тэс хуурай уур амьсгалтай. Даланжаргалан сум болон түүний орчин тойрны цаг уурын элементүүдийн сүүлийн 10 жилийн ажиглалтын дунджаар 16.5 мм хур тунадас унах бөгөөд үүний ихэнх нь 4-10-н сарын хооронд унана. 7-р сард дулааны дундаж хэм +25 градус, 01 сард -23 градус хүрч хүйтрэнэ. Дулааны улиралд +10 градусаас дээш хугацааны нийлбэр 2000-2800 градус, ургамал ургалтын үе нь 120-130 хоног байдаг. Жилийн туршид гол төлөв баруун

зүгийн салхи зонхилох ба 4, 5 саруудад салхины хүч эрчимждэг.

Хөрсөн бүрхэвч

БОНБНУ-ний хүрээнд хийгдсэн хээрийн судалгааны үр дүнд тус төслийн талбай орчим нь хөрс газарзүйн мужлалтын хувьд Хангайн их мужийн өргөрөгийн бүсшилттэй нутгийн Цайвархүрэн хөрсний дэд бүсийн хүрээнд Баяндэлгэрийн хөрсний тойрогт хамрагдаж байна. Төсөл хэрэгжиж буй бүс нутаг нь хуурай хээр, говийн бүсийн зааг толгодорхог ландшафт зонхилсон бөгөөд толгодын хэсгээр сайргархаг цайвархүрэн хөрс, харьцангуй тэгшивтэр гадаргаар карбонаттай цайвархүрэн хөрс, хөндий хотгорын хэсгээр хужирлаг бараан, зузаан элсэнцэр цайвархүрэн хөрс тус тус тархсан.

Ургамлын аймаг

Төслийн талбай нь ургамлын мужлалаар Төв Азийн тал талархуу газрын ургамалжил бүхий Евразийн хээрийн их муж, хуурайдуу хэв шинжийн Алтанширээгийн тойрогт багтдаг ба газрын гадаргын хувьд цав толгод ухаа гүвээ, хотос хотгор, тойром бүхий гадарга зонхилох бөгөөд голлон тааралдах ургамлын хэв шинж нь бэсрэг уулсын налуу хажуу тал хөндийд крыловын хялгана-сөөгөнцөр, таана-сайрын хялгана, говийн хялгана-заримдаг сөөгөнцөр, дэрс бүхий таана-бударгана зэрэг цөлөрхөг хээрийн бүлгэмдэл зонхилсон байх бөгөөд элсэрхэг сайргархаг тэгш талархаг талаар Зүүнгарын улаанбударгана, сэдэргэнэ, таана зэрэг цөл хээрийн ургамалжилттай.

Гадаргын болон гүний ус

Ус зүйн хувьд Төв Азийн гадагш урсгалгүй ай савын бүсэд хамаарах бөгөөд гидрогеологийн мужлалаар улирлын хомс тэжээлтэй мужид байрладаг. Энэхүү ай савд гол мөрний сүлжээ маш бага бөгөөд нэгж талбайд ноогдох голын нийлбэр урт нь 0.01 км/км. кв- аас доош байдаг. Даланжаргалан сумын нутаг нь “ Умард Говийн Гүвээт-Халхын Дундад Тал” усны сав газарт хамаарах бөгөөд гадаргын ус бараг байхгүй ба унд ахуй, үйлдвэрлэл, үйлчилгээнд газрын доорх усыг ашигладаг. Сансрын болон геологи-техтоникийн зураг, усны эрэл хайгуулын судалгааны дүнгээс харахад тектоникийн хагаралын бүсэд оршдог. Нүүрсний үе, давхраасууд нь синклиналь тогтоцтой, харьцангуй бага гүнд байрлах ба 5-10 градусын уналтай ба геологи, тектоникийн тогтоц нь энгийн бүтцийг үүсгэнэ. Усжилт бүхий тектоникийн хагарал, ан цав багатай, тохрол, өргөгдөл, суултанд олон удаа орсон блок байхгүй байна. Ул суурийн хурдас нь уст үе, давхарга багатай шаварлаг хурдас тухайлбал хар, хар саарал өнгийн аргиллит, алевролит, алевро-элсэнчулуу, шаварлаг чулуулгаас тогтох ба усжилт бага байдаг онцлогтой. Ордын гидрогеологийн нөхцлийн хувьд дээрх хүчин зүйлүүд энгийн нөхцөлтэй ангилалд оруулах боломжийг бүрдүүлж байна.

Ашиглаж байгаа худгийн мэдээлэл

Байршил	Худгийн нэр	Уурхайгаас	Худгийн гүн/ л.с	Зориулалт
Дорноговь, Даланжаргалан, Элдэв баг, Зүүндалан уурхай	Цооног 0603-18189	Уурхайн кемпийн хажууд	56 м/0.33	Унд, ахуй

Амьтны аймаг

“Билэгт Баялаг” ХХК-ийн Зүүндалан, Далангийн төслийн ойр орчим говь, цөлийн амьтад голчлон тархсан ба ихэнх нь “Монгол орны 2 нутагтан, мөлхөгчдийн улаан данс- 2006 он”, “Монгол орны шувууны улаан данс-2011 он “Бүс нутгийн болон олон улсын үнэлгээний анхааралд өртхөөргүй /ЛС/ буюу өргөн тархац нутагтай элбэг гэсэн зүйл ангилалд орсон байна. Алагтолгой орчмын нүүрсний орд нь олон жилийн турш уул уурхайн хайгуул, олборлолтын үйл ажиллагаанд өртсөний улмаас амьтны аймгийн төрөл зүйлээр ядмаг юм.

Түүх соёлын дурсгалт газрууд

Ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй талбайд 2018 онд ШУА-ийн Палеонтологийн төвийн доктор Н.Ичинноровоор ахлуулсан баг судалгааны ажлыг хийсэн ба талбайд археологийн болон соёлын үнэт зүйл бүхий зүйлс илрээгүй байна.

Уурхайн үйл ажиллагааны талаарх мэдээлэл

Зүүндалан, Далангийн чулуун нүүрсний ордыг агуулж байгаа грабен хэлбэрийн хотос структур нь хожуу мезозойн ревивацийн нөлөөллөөр үүссэн бөгөөд Говийн атриат бүсэд хамаарагдана. Алагтогоогийн нүүрсний ордын районд, дээд юрагийн тунамал хурдас, дээд юра доод цэрдийн Цагаанцав формацийн бялхмал тунамал хурдас, доод цэрдийн туфоген тунамал хурдас, дөрөвдөгчийн эх газрын тунамал хурдас тархсан байдаг.Нүүрс агуулсан хурдасны шинж чанарыг доор дурьдвал:

Аргиллит нь цайвар саарлаас хар саарал өнгөтэй, заримдаа шаравтар болон ногоовтор туяатай, ургамлын нүүрсжсэн үлдэгдэл, төмрийн усан ислийн хүрэн толбо (исэлдсэн хэсэгтээ), пирит (гүндээ) агуулсан, бүхэллэг (плотный) заримдаа конковатый хэлбэртэй байна.

Алевролит нь саарал өнгөтэй бүхэллэг, заримдаа конковатый хэлбэртэй мөн пирит болон төмрийн усан исэл агуулдаг болно. Нүүрсний давхраасны дээд талаар голчлон тааралддаг. Элсэн чулуу нь шаравтар болон хүрэн туяатай, цагаан саарлаас саарал өнгөтэй, янз бүрийн ширхэгтэй, янз бүрийн мөлгөржилт бүхий янз бүрийн найрлагатай ширхэгүүдээс тогтоно.

Гравелит нь муухан мөлгөржсөн бялхмал болон цахиуржсан чулуулаг бүхий жижиг мөхлөгүүдээс тогтоно.

Конгломерат нь том хайргатай, хайрга нь дунд зэргийн мөлгөржсөн метаморф чулуулгаас тогтоно.

Олборлолтын технологи

Ордын геологийн тогтоц, уул техникийн нөхцөлөөс хамааруулан хөрсөнд өрөмдлөг тэсэлгээтэй, экскаватор автосамсовалын хослолоор хөрсний гадаад болон дотоод овоолготой нүүрс олборлолтын ажил нь нүүрсийг уурхайгаас ухаж ачих, нүүрсийг төмөр замын Олон овоо өртөө хүртэл авто тээврээр тээвэрлэх гэсэн үндсэн процессуудаас бүрдэнэ.Ил уурхайн хэлбэр, хэмжээ, чулуулгийн технологийн шинж чанар зэрэг суурь нөхцөлүүдийг үндэслэн дараах механикжуулалтын бүтцийг хөрс хуулалт, олборлолтын ажилд тохиромжтой гэж үзэж байна.

Уулын ажлын механикжуулалтын бүтэц

Хийгдэх ажил	Процесс		Тоног төхөөрөмж	
Шимт хөрс хуулалт	Ухаж түрэх	Экскавац/тээвэр	Овоолох	
	Бульдозер	Экскаватор/автосамосвал	Бульдозер	
Хөрс хуулалт	Ухаж ачих	Тээвэрлэх	Овоолго	
	Экскаватор	Автосамосвал	Бульдозер	
Нүүрс олборлолт	Экскавац	Тээвэр	Хадгалалт	Боловсруулалт
	Экскаватор	Автосамосвал	Агуулах	Угаан ангилах

Уурхайн барилга байгууламж

Ажилчдын тосгон нь ил уурхайгаас 1.1 км зайд баруун зүгт 4 га талбайд байрладаг. Үүнд харуулын байр, уурын зуух, оффис, 90-100 хүний багтаамжтай сууц, нэг удаадаа 40 хүн хоолох хүчин чадалтай гал зуух, 5 хүн зэрэг ашиглах боломжтой нийтийн ариун цэврийн газар, өдөрт 8-10 хүний хувцас угаах хүчин чадалтай угаалгын өрөө, техник засварын газрууд тус тус байна.

Түлшний агуулах нь 10 тонны 1 ш, 25 тонны 1 ш дизель түлш хадгалах ёмкостуудтай. Галын аюулаас сэргийлэх багаж техник, аянга зайлуулагч гэрэлтүүлэг зэргээр тоноглогдсон. 3000 литрийн багтаамжтай, тоолууртай, 100 л/мин шахах хүчин чадалтай явуулын түгээгүүрээр хүнд машин механизмуудад түлш тараадаг.



Зүүндалан, Далангийн нүүрсний уурхайн 2023 оны хөрс хуулалт, нүүрс олборлолтын төлөвлөгөө

Үзүүлэлт	Хэмжих нэгж	Жилийн төлөвлөгөө	1-р улирал				2-р улирал				3-р улирал				4-р улирал			
			1	2	3	Дүн	4	5	6	Дүн	7	8	9	Дүн	10	11	12	Дүн
Хөрс хуулалт	мян. м3	1856.2	154.8	154.8	154.8	464.4	154.8	154.8	154.6	464.2	154.6	154.6	154.6	463.8	154.6	154.6	154.6	463.8
Нүүрс олборлолт	мян. м3	406.103	33.5077	33.8154	33.5077	100.831	33.8385	33.8385	33.8385	101.515	34.5077	33.8385	33.8385	102.185	33.8577	33.8577	33.8577	101.573
Нүүрс олборлолт	мян. тн	527.935	43.56	43.96	43.56	131.08	43.99	43.99	43.99	131.97	44.86	43.99	43.99	132.84	44.015	44.015	44.015	132.045
Нүүрс борлуулалт	мян. тн	527.935	43.56	43.96	43.56	131.08	43.99	43.99	43.99	131.97	44.86	43.99	43.99	132.84	44.015	44.015	44.015	132.045

Уурхайд ашиглаж буй техник, тоног төхөөрөмж

Үзүүлэлт	Doosan-DX520
Утгуурын багтаамж, м ³	3.5
Хөдөлгүүрийн чадал, кВт	345
Нийт жин, кг	70000
Гарны урт, м	8.4
Мах хурд км/цаг	5.2
Жилийн бүтээл, м ³	1180000



Үзүүлэлт	CDoosan-DX520
Утгуурын багтаамж, м ³	2.8
Хөдөлгүүрийн чадал, кВт	103
Нийт жин, кг	35100
Гарны урт, м	3.2
Мах хурд км/цаг	5.5
Жилийн бүтээл, м ³	275000



Үзүүлэлт	Shacman
Даац, тн	70
Хөдөлгүүрийн чадал	426 м.х
Нийт жин, тн	25
Тэвшний багтаамж, м ³	65
Хурд км/цаг	75
Жилийн бүтээл, м ³	95660



Үзүүлэлт	Nordbenz
Даац, тн	25
Хөдөлгүүрийн чадал	371 м.х
Нийт жин, тн	13.7
Тэвшний багтаамж, м ³	18.2
Хурд, км/цаг	70
Жилийн бүтээл, м ³	160000



Үзүүлэлт	Howo-371
Даац, тн	70
Хөдөлгүүрийн чадал	371 hp
Мах хурд км/цаг	70
Жилийн бүтээл, м ³	400000



Өрөмдлөгийн ажлыг 110мм-140мм диаметртэй эргэлтэт цохилтот өрмийн машинаар гүйцэтгэнэ. Нүүрсийг 3.2 м³ утгуурын багтаамжтай SEM дугуйт ачигчаар 70 тонн даацтай шланз машинд ачина.

ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ НӨЛӨӨЛӨЛ

Зүүндалан, Далангийн чулуун нүүрсний ордын БОНБНУ-ний нэмэлт тодотгол-2023 он

Технологийн үйл ажиллагааны байгаль орчинд үзүүлэх болзошгүй нөлөөлөл

Байгаль орчин, нийгэм эдийн засгийн бүрэлдэхүүн хэсгүүд	Хөрс хуулах	Өрөмдлөг, тэсэлгээ	Хөрсний овоолго	Нүүрс ачих, тээвэрлэх	Усны хэрэглээ, ус бохирдох	Нүүрс тээвэрлэх, зөөх
Агаарын чанар	7/4	3/4	4/5			2/3
Гадаргын ус						
Гүний ус	2/2	1/1		2/3	8/9	
Хөрс	6/8		7/7			4/5
Ургамал	8/8		4/4			4/5
Ой						
Зэрлэг амьтан	2/3	1/1	1/1			2/3
Усны амьтан, организм						
Геологийн тогтоц	5/7	3/5	3/3	6/6		
Байгалийн үзэсгэлэнт тогтоц	7/8		5/6			3/2
Бэлчээр	3/4		1/2		1/1	1/1
Хүний эрүүл мэнд	2/2	1/1	1/1	1/1	2/3	2/3
Дүн	42/46	9/12	26/29	9/10	11/13	13/22

Дээрх хүснэгтийн босоо багануудын нийлбэр дүнгээс үзвэл хөрс хуулах үйл ажиллагаа нь агаар, хөрс, ургамал, геологийн тогтоц зэрэгт ихээхэн нөлөөтэй байх нь харагдаж байна. Нөлөөлөлд хамгийн их өртөгч нь агаар, хөрс, ургамал, геологийн тогтоц зэрэг юм.

Өрөмдлөг тэсэлгээ: Төслийн өрөмдлөг тэсэлгээний ажил явуулах үед тоос агаарт гарах, мөн ойр орчмын хөрс, ургамлын бүрхүүлд нөлөөлж байна. Түүнчлэн өрөмдлөг тэсэлгээний ажил нь тухайн газар орны геологийн тогтоцыг шууд өөрчилж буй тул нөлөөллийн өндөр оноо өгсөн байна.

Хөрс ухаж ачих, тээвэрлэх: Хөрсийг ухаж ачих, тээвэрлэх процессын үед агаарт тоосжилт үүсэх, хөрс, ургамлан бүрхэвчид нөлөөлөх зэрэг сөрөг нөлөөлөл үүснэ.

Хөрсийг овоолох: Хөрс овоолох үед үүсэх гол сөрөг нөлөөлөл нь тоосжилт байх юм. Мөн хөрсний овоолгын талбайн хөрс, ургамал бүрхэвчид сөрөг нөлөө үзүүлнэ.

Нүүрс ухаж ачих, тээвэрлэх: Нүүрс ухаж ачих, тээвэрлэх процессын үед агаарт тоос гарах, геологийн тогтоц өөрчлөгдөх зэрэг сөрөг нөлөөлөл үүснэ.

Түүрс тээвэрлэлт: Нүүрс тээвэрлэх үед гадаад тээврийн замаас босох тоос нь гол сөрөг нөлөөлөл байх бөгөөд гадаад тээврийн замыг хатуу хучилттай болгосноор энэ төрлийн сөрөг нөлөөлөл багасах

боломжтой юм.

Төслийн технологийн үйл ажиллагаанаас үүсэх гол сөрөг нөлөөлөл нь агаар дахь тоосжилт байх нь дээрх хүснэгтээс харагдах бөгөөд мөн ургамал, хөрсөнд нөлөөлөх сөрөг нөлөөлөл нь гол сөрөг нөлөөлөлд тооцогдож байна.

БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ

Энэхүү төлөвлөгөөний гол зорилт нь байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний тайланд тусгасан байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө болон орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг үндэслэн байгаль орчныг хамгаалах талаар авах удирдлага зохион байгуулалтын болон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээ, уг төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардагдах хугацаа, хөрөнгө зардлыг бодитойгоор тооцож тусгах.

БОНБУ-ний сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах талаарх заалтуудыг хэрэгжүүлэх, хэрэгжүүлэх боломжтой эсэхийг бодит байдал дээр турших.

Бид төслийн үйл ажиллагаанаас хүрээлэн буй орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг байж болох хамгийн бага хэмжээнд байлгахыг зорих бөгөөд байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний хэрэгжилтийг тогтмол хянаж ажиллаж байна.

“Билэгт Баялаг” ХХК нь 2023 онд Байгаль орчныг хамгаалах менежментийн төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлсэн болно.

СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Агаарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний хүрээнд

№	Арга хэмжээ	Хэрэгжүүлэгч	Тайлбар	Биелэлт
1	Тоос болон тоосонцорын үзүүлэлтүүдийн түвшинг тодорхой давтамжтайгаар, сонгосон цэгүүд дээр хэмжилт хийх	БО-ны ажилтан	Уурхайн нөлөөллийн 6 цэгт УБ хотын ЦУОШГ-ын харьяа Байгаль орчны хэмжил зүйн төв лабораторийн ажилтан Б.Батхишигээр тоосонцор болон агаарт агуулагдаж байгаа хортой нэгдлүүдийн үзүүлэлтүүдийг тодорхойлсон. Агаарын чанарын стандарт MNS 4585:2016. 2023 оны 7 сард БОАЖЯ-с ирсэн төлөвлөгөөт хээрийн шинжилгээний багийн бүрэлдэхүүний хамт уурхайн шимт хөрс, ул талбай, отвал, амрах хотхон, Технологийн замаас агаарын шинжилгээг авсан.	100 %
2	Уурхайн доторх зам, технологийн замд усалгаа хийх	Гэрээт компани, Уул геологийн хэлтэс	Гэрээт компанийн 1 автомашинаар өдөр бүр уурхайн бүс доторх замын усалгааг хийж байна.	100 %
3	Нүүрс тээвэрлэдэг машинуудад бүтээлэг хэрэглэх.	Гэрээт компани, ХАБ, БО-ны ажилтан нар	Нүүрс тээвэрлэдэг машинууд бүтээлэг хэрэглэж хэвшсэн.	100 %
4	Уурхай орчимд замын тэмдэг тэмдэглэгээг сайтар байршуулах, нэг замаар явах нөхцөлийг бүрдүүлж замын хашилт хаалт, даланг уурхайн ашиглалтын замын дагуу хийх.	ХАБ, БО-ны ажилтан нар	Кемп, технологийн зам, карьер доторх замуудад шаардлагатай замын тэмдэглэгээг байрлуулсан. Олон салаа зам гарахаас сэргийлж лицензийн талбайн дагуу механик хаалт хашилтыг хийсэн.	100 %

Гол ба болзошгүй сөрөг нөлөө		Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Биелэлт
1	Уурхайлалт, овоолго болон уурхайн замаас тоосжилт	Орчны тоосжилтыг багасгах зорилгоор технологийн зам, талбайд тогтмол усалгаа хийгдэж хурдны хязгаарт хяналт тавина	100%
2	Үүсэх	Тоосжилт (PM2,5, PM10) хэмжих төхөөрөмжөөр агаарын чанар, тоосжилтыг тогтмол хэмжих, хянах	100%

Орчны тоосжилтыг багасгах зорилгоор замын усалгаа хийх ажлын биелэлт

Орчны тоосжилтыг бууруулах зорилгоор уурхайн доторх технологийн зам, талбайд өдөр бүр шүүрлийн ус болон хур борооны тогтоол усаар усан усны бүртгэлийг өдөр бүр хөтлөн ажиллаж байна.

Усны хэрэглээ м3

Ангилал		Нэгж	Сардаа												Нийт
			1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	
Үйлдвэрлэлийн зориулалт	Худаг	м ³	15	15	15	180	180	180	15	15	15	15	15	15	675
	Шүүрэл	м ³	-	-	-	976	2303	255							3534
	Гадарга	м ³	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	






График 1. Тоосжилт бууруулах зорилгоор ашигласан усны үзүүлэлт

УБ хотын ЦУОШГ-ын харьяа Байгаль орчны хэмжил зүйн төв лабораторийн тоосжилт хэмжигч багаж Дасттрак 8530, дуу чимээ хэмжигч Тесто 815 багажуудыг ашиглаж “Билэгт Баялаг” ХХК-ийн Зүүндалан уурхайн 3 цэгт 2023 оны 05-р сарын 04-ний өдөр шинжээч Б.Батхишигээр хэмжилтийн ажлыг хийлгүүлсэн.

Зураг 1. Тоосны хэмжилт хийж байгаа нь



Зураг 2. Дуу чимээний хэмжилт хийж байгаа нь



Зүүндалан, Далангийн уурхайд гэрээгээр олборлолт явуулдаг “Шнашл” ХХК-ний 1 автомашинаар өдөр бүр уурхайн бүст тогтмол усалгаа хийж байна. Усалгаанд уурхайн карьер доторх ус хуримтлуулах талбайн ус мөн уурхайн шүүрлийн усыг ашиглаж байна.



Зураг 3,4. Замын усалгааг хийж байгаа нь



Зураг 5. Нүүрс тээврийн бүтээлэгтэй машин



Зураг 6. Уурхайн замыг тэмдэгжүүлсэн байдал

Олборлолт явуулж байгаа талбайн ойр орчим нь олон жилийн турш уул уурхайн үйл ажиллагаанд өртсөн, олон уурхайнууд үйл ажиллагаа явуулдаг, орон нутгийн иргэд их зорчдог зэрэг шалтгааны улмаас олон салаа зам ихтэй. Иймээс лицензийн талбайн дагуу хаалт хашилт хийж замын тэмдэг тэмдэглэгээг шаардлагатай газар байрлуулсанаар олон салаа зам үүсэх, тоосжилт ихсэх эрсдэлээс сэргийлж байна.




Зураг 7. Лицензийн талбайн дагуу хийсэн хаалт

Хөрсөнд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний хүрээнд

№	Арга хэмжээ	Хэрэгжүүлэгч	Тайлбар	Биелэлт
1	Хөрс хуулалтанд өртөх талбайн үржил шимт хөрсийг тусад нь овоолон биологийн нөхөн сэргээлтэд ашиглах.	Гэрээт компани, БО-ны ажилтан	1.2 га-д 60000 м ³ шимт хөрсийг 4-8 метр өндөр овоолон анхаарах самбар байрлуулан БНС-нд ашиглахаар хадгалж байна.	100 %
2	Уурхайн ашиглалтын талбайг үерийн уснаас хамгаалах далан шуудуу байгуулах.	Гэрээт компани	Олборлолт явуулж байгаа талбайг тойруулан үерийн хамгаалалтын шуудуу ухсан.	100%
3	Ахуйн хог хаягдал болон ажилласан тос масло, техникийн бусад шингэн материалыг хөрсөнд асгарахаас сэргийлэх.	Гэрээт компани, БО-ны ажилтан	Ахуйн хог хаягдлыг кемпийн түр хогийн цэгт хуримтлуулаад сумын төвийн хогийн цэгт хаядаг. Ажилласан тос масло, техникийн бусад шингэн материалыг бетонон хучилттай, хашаатай талбайд түр хадгалж байна. Тушаах нөөц бүрдсэн үед УБ хот дахь хаягдал тос масло авдаг Жи-Би-Ойл ХХК-д нийлүүлэхээр БОАЖЯ-наас бүртгэлийн дугаар авсан. Засварын газрын хажууд бохирдсон хөрс түр хадгалах поошигнууд байрлуулсан. Мөн засварын талбайд хатуу хучилттай засварын шоп баригдаж байна. 2023 оны 10-р сарын 31-ний өдрийн байдлаар засварын байранд нийт 97,5 сая төгрөг зарцуулаад байна.	90 %
4	Хөрс, хаягдал усны мониторингийн цэгүүдийг нарийвчлан тогтоож, мэргэжлийн байгууллагаар судалгаа шинжилгээ хийлгүүлэх.	Мэргэжлийн байгууллага, БО-ны ажилтан	Уурхайн нөлөөллийн 3 цэгээс хөрсний, 1 цэгээс хаягдал усны дээж авч шинжлүүлсэн.	100 %
5	Газар, хаягдал устай холбоотой гэрээ дүгнэлт зөвшөөрөл авах, төлбөрийг хугацаанд нь төлөх	Уурхайн дарга	Орон нутгийн засаг захиргаатай 2023 газар ашиглах, хог хаягдлын гэрээг тус тус байгуулсан. ГГХДТСГ-ын захиргааны хаягдал усны дүгнэлтийг мөрдөн ажиллаж байна. Төлбөрийг улирал бүрээр төлсөн.	100 %

6	Кемпийн ногоон байгууламжийг нэмэгдүүлж арчилгаа, усалгааг сайжруулах чиглэлээр	БО-ны ажилтан	2023 онд кемпийн ногоон байгууламжийг нэмэгдүүлэх зорилгоор 25 мод шинээр тарьж 8 м.кв талбайд цэцгийн мандал хийсэн. Улиас, хайлаас, тэхийн шээг зэрэг 85 мод. Арчилгаа усалгааг тогтмол хийж байна.	100 %
---	---	---------------	---	-------



Зураг 8. Шимт хөрсний овоолго



Зураг 9. Уурхайн түр хогийн цэг

Зураг 10. Ажилласан тос масло, техникийн бусад

Аж ахуйн нэгжийг бүртгэх бүртгэлийн хуудас

№	Бүртгэлийн дугаар	Регистрийн дугаар	Аж ахуйн нэгжийн нэр	Байгууламжийн нэр	Үйл ажиллагааны төрөл	Холбоо барих хаяг
1	000432	5294088	Билэгтбаялаг ХХК	нүүрс олборлох уурхай	Аюултай хог хаягдал үүсгэгч,	Эрдэнэ Энхзаяа, гүйцэтгэх захирал, 99999979

Зураг 11. БОАЖЯ-наас авсан аюултай хог хаягдал үүсгэгчийн бүртгэлийн дугаар



Зураг 12. Засварын газрын цементэн талбайг шинэчилж томруулж байгаа нь



Зураг 13. Стандартын дагуу авсан дээжнүүд



Зураг 14. Хөрсний дээж авч байгаа нь





Зураг 15.Кемтийн ногоон байгууламж

Даланжаргалан сумын ЗДТГ-тай 2023 оны газрын гэрээ, хог хаягдлын гэрээ, ус ашиглах гэрээг тус тус байгуулсан. Ус ашиглах зөвшөөрлийг Дорноговь аймгийн БОАЖГазраас авсан. Унд ахуйн хэрэглээний ус, хаягдал усны дүгнэлтийг УГГХДТСГ-ын захиргаанаас авч үйл ажиллагаандаа тусган ажиллаж байна.Төлбөрийг улирал бүр орон нутгийн төсөвт төвлөрүүлж байна. Хавсралт хэсэгт дүгнэлт гэрээнүүдийн хуулбарыг хавсаргав.



Зураг 16.Моднуудад 9, 10-р сард цэнэг усалгаа хийсэн байдал



Зураг 17. Кемпийн ногоон байгууламж тэмдэг тэмдэглэгээ хийсэн байдал



Усан орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний хүрээнд

№	Арга хэмжээ	Хэрэгжүүлэгч	Тайлбар	Биелэлт
1	Унд ахуйд ашиглах усны дүгнэлт гаргуулах, гэрээ байгуулах, төлбөр төлөх	Уурхайн дарга, БО-ны ажилтан	Даланжаргалан сумын ЗДТГ-тай 2023 оны, ус ашиглах гэрээг байгуулсан. Ус ашиглах зөвшөөрлийг Дорноговь аймгийн БОАЖГазраас авсан. Унд ахуйн хэрэглээний ус, хаягдал усны дүгнэлтийг УГГХДТСГ-ын захиргаанаас авч үйл ажиллагаандаа тусган ажиллаж байна. Төлбөрийг улирал бүр орон нутгийн төсөвт төвлөрүүлж байна.	100 %
2	Гүний худагт хашаажуулалт хийх, шаардлагатай тэмдэг тэмдэглэгээ байршуулах.	Кемп менежер, БО-ны ажилтан	Уурхайн унд ахуйн хэрэглээнд ашигладаг худгийн байрыг байнга цоожилж, онцгой хамгаалалтын бүс тогтоож хашаажуулсан.	100 %
3	Хяналт инжилгээний хөтөлбөрийг хэрэгжүүлэх	БО-ны ажилтан	Унд ахуй, бохир ус, уурхайн шүүрлийн усыг БОМТ-д тусгасан хуваарийн дагуу ХААИС-ын лаборатори, Газарзүй Геоэкологийн хүрээлэнгийн лабораториар шинжилгээ хийлгэв.	100 %
4	Ажилчдын унд ахуйн усыг ундны усны стандартад нийцүүлэх судалгааны ажил хийх.	Кемп менежер, БО-ны ажилтан	Герман улсын Сименс фирмийн ус цэвэршүүлэгч төхөөрөмжийг гал тогоонд суурилуулж ундны усыг шүүж байна.	100 %



Зураг 18. Шүүрлийн уснаас дээж авч байгаа нь



Зураг 19. Худгийн тоолуур



Зураг 20. Унд, ахуйн хэрэглээний худаг



Зураг 21. Ундны уснаас дээж авч байгаа нь

СТАНДАРТ, ХЭМЖИЛ ЗҮЙН ГАЗАР
УСНЫ ТООЛУУРЫН
БАТАЛГААЖУУЛАЛТЫН ГЭРЧИЛГЭЭ

№ **065657**
Билэгт Баялаг ХХК -д
(хэрэглэгчийн нэр)

ашиглаж байгаа *LX5G-25F* загварын *3.5 1/4*
хэмжих хязгаартай, *25* мм-ийн голчтой № *00432* -ын
халуун, хүйтэн усны тоолуурыг № *047* лацаар битүүмжилж
(доогуур зурах)

2023 оны *05* -р сарын *25* -ны өдөр хүртэл улсын
баталгаажуулалтын гэрчилгээ олгов.

Шалгалтын дараах заалт: *0714* м³

Лабораторийн тэмдэг Улсын шалгагчийн
гарын үсэг, тэмдэг

2023 оны *05* -р сарын *25* -ны өдөр

Зураг 22. Усны тоолуурын баталгаажуулалтын гэрчилгээ, худагт суурилуулсан акт

“ЧАНДМАНЬ-ИЛЧ” ХХК
УСНЫ ТООЛУУР ХОЛБОЛТ, УГСРАЛТЫН АКТ

Билэгт Баялаг ХХК -д ашиглаж байгаа
LX5G-25F марк *00432* дугаар *25* голчтой *0714* заалттай хүйтэн усны тоолуурын холболт, угсралтын
ажлыг хийв.

Тоолуурын холболт, угсралтыг хийсэн:
Усны тоолуурын техникч
Засварчин: *Б.Эрдэнэбат* / (гарын үсэг) / (овог нэр)
Ковчигмаг / (гарын үсэг) / (овог нэр)

Хүлээн авсан: *О.Оюун* / (гарын үсэг) / *Оюун* / (овог нэр)

2023 оны 05-р сарын 26-ны өдөр

НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Уурхайн олборлолтын гурван сарын хугацаанд Техникийн нөхөн сэргээлтийн ажил 0,8 га талбайд дотоод овоолго үүсгэн ажилласан, биологийн нөхөн сэргээлтийн ажил уурхайн түр зогсолтоос шалтгаалан хугацаандаа хийгдээгүй байна.



ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

2023 оны 10 дугаар сарын 05-ны өдөр “Билэгт Баялаг” ХХК нь Дорноговь аймгийн Даланжаргалан сумын Сээрийн булаг газарт эзэн холбогдогчгүй хууль бусаар жонш олборлож орхигдож үлдсэн 0.3 га газарт нүхийг булах болон айлын бууц түрэн техникийн нөхөн сэргээлтийн ажлыг хийж орон нутагт хүлээлгэн өгсөн.

**ЭВДЭРСЭН ГАЗАРТ НӨХӨН СЭРГЭЭЛТ ХИЙСЭН
ГАЗРЫГ ХҮЛЭЭЖ АВАХ АКТ**

2023 оны 10 дугаар сарын 05-ний өдөр

1. Байршлын мэдээлэл	
1.1. Аймаг, нийслэлийн нэр	Дорноговь
1.2. Сум, дүүргийн нэр	Даланжаргалан
1.3. Газрын нэр	Сээрийн Булаг
2. Нөхөн сэргээлт хийсэн байгууллагын мэдээлэл	
2.1. Нөхөн сэргээлт хийсэн аж ахуй нэгжийн нэр, регистр	Билэгт Баялаг, 5294088
2.2. Хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр	АНН-н нөхөн сэргээлтийн сангаас
2.3. Тус газрын эвдрэлд өртсөн шалтгаан	Хууль бусаар жонш олборлосон
2.4. Тус талбайд нийт эвдрэлд өртсөн талбайн хэмжээ (га)	0,3
2.5. Газрын хэвлийн нөхөн сэргээлт хийх мэргэжлийн байгууллагын эрхтэй эсэх, зөвшөөрлийн дугаар	үгүй
3. 2023 онд хүлээлгэн өгч буй нөхөн сэргээлтийн мэдээлэл	
Техникийн нөхөн сэргээлт - Талбайн хэмжээ (0,3га) - Зардлын хэмжээ (1,587,600)	Биологийн нөхөн сэргээлт - Талбайн хэмжээ (га) - Биологийн нөхөн сэргээлтэд ашигласан мод, сөөг, ургамлын зүйлийн нэр, ургамалжуулсан байдал - Зардлын хэмжээ ()
4. Орон зайн мэдээлэл	
4.1. Нөхөн сэргээлт хийгдсэн газрын фото зураг	4.2. Хэмжилт, зураглал - Кадастрын зураглал хийсэн мэргэжлийн байгууллага болон хэмжилт хийсэн хүний нэр:

Б.Сандагдорж
- Хэмжилтэд ашигласан программ, тоног төхөөрөмж,
- Холбогдох утас: 88034232
Гарын үсэг:

№	Өргөрөг	Уртраг
Техникийн нөхөн сэргээлт		
1	46°3'54,14	108° 48'15,91
2	46°3'51,76	108° 48'15,37
3	46°3'51,68	108° 48'19,73
4	46°3'54,76	108° 48'19,69
5	46°3'42,03	108° 48'7,88
Биологийн нөхөн сэргээлт		
1		
2		

4.3 Нөхөн сэргээлт хийсэн газрын солбицол

Жич: 4-өөс доошгүй эргэлтийн цэгийн солбицол байна.

Нөхөн сэргээлт хийсэн газарт хэмжилт хийж талбайн хэмжээг тогтоон полигон хэлбэрээр share.file үүсгэн флаш болон CD-нд хуулж акттай хавсаргана.

5. Мэдээллийн сангийн бүртгэл
Нөхөн сэргээлтийг хүлээн авсан ажлын хэсэг нь Байгаль орчны мэдээллийн сангийн www.elic.mn цахим системийн Нөхөн сэргээлтийн мэдээллийн дэд санд заавал бүртгүүлнэ.
Жич: Мэдээллийн санд бүртгээгүй тохиолдолд нөхөн сэргээлтийг хүлээн авсан актыг хүчинтэйд тооцохгүй.
Мэдээлэл оруулсан хүний нэр, албан тушаал:
Гарын үсэг:
Огноо:
Нэмэлт мэдээлэл:



Зураг 23. Дүйцүүлэн хамгаалалтын ажлыг хүлээлгэн өгсөн акт







Зураг 24. Дүйцүүлэн хамгаалалтын ажлын өмнөх болон дараах зураг

НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Уурхайн үйл ажиллагаа явагдаж байгаа талбай болон эрчимтэй сөрөг нөлөө үзүүлэх бүст айл өрх, өвөлжөө хаваржаа байхгүй учраас 2023 оны БОМТ-нд нүүлгэн шилжүүлэх болон нөхөн олговор олгох ямар нэгэн ажил тусгагдаагүй.

ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

2018 онд “Соёлын өвийг хамгаалах тухай” хуулийн 6-р бүлгийн 17-р зүйлийн 10-т заасаны дагуу ШУА-ийн Археологи, Палентлогийн хүрээлэн төслийн талбайд хайгуулын ажлыг хийсэн. Судалгаа хайгуулын ажлын хүрээнд эртний ургамал амьтаны ул мөр, түүхийн үнэт олдвор илрээгүй. Дүгнэлтийг хавсаргав.



Зураг 25. Археологийн, Палеонтологийн дүгнэлт

ХИМИЙН БОДИСЫН ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Уурхай нь үйлдвэрлэлийн үйл ажиллагаандаа ямар 1-н химийн бодис хэрэглэдэггүй бөгөөд тэсэлгээнд ашиглах бодисыг тэсэлгээ хийх үед “Их Оч” ХХК-ийн ажилчид авчирч хийдэг. Уурхайн бүст тэсэлгээний материал болон аюултай химийн бодисыг хадгалдаггүй. Шатах тослох материал, хөргүүрийн шингэнийг контейнерт хадгалдаг. Угаалгын цэгт ашигладаг химийн бодисын агууламж бүхий бодисуудыг бүртгэлжүүлэн мэдээллийн сан үүсгэж, хэрэглээнд нь хяналт тавьж ажиллаж байна.

Ахуйн хэрэглээний бүтээгдэхүүн

Материалын төрөл, нэр	Зориулалт
Угаалгын нунтаг ОМО	Хувцас, цагаан хэрэглэл угаах
Цайруулагч бодис Ace	Хувцас, цагаан хэрэглэл өнгө оруулах
Тос толбо арилгагч Asperox, Fairy	Тостой хувцасны тосыг задлах, аяга таваг угаах
Ариутгагч Stern	Хувцас хэрэглэлийг ариутгах

ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Зүүндалан, Далангийн уурхайд гэрээгээр олборлолт явуулдаг “Шнашл” ХХК-ний захирлын 2023 онд Бүх нийтийн цэвэрлэгээ хийх хуваарийг батлуулж уурхайн нийт ажилчид, гэрээт байгууллагын ажилчид даган мөрдөж байна. Ажилчдын амрах байр, оффис, гал тогоо зэрэг нь бүгд гадна дотроо хогийн савтай. Ажилчдын өрөөнүүдийн үүдэнд мөн дотор хогийн савнууд байрлуулсан. Эдгээр газраас гарсан ахуйн хог хаягдлыг кемпийн үйлчлэгч уурхайн түр хогийн цэгт ангилан ялгаж хаядаг. Түр хогийн цэгт цугларсан хог хаягдлыг Даланжаргалан сумын нэгдсэн хогийн цэгт хаядаг. Ахуйн хог хаягдлын бүртгэлийг кемпийн үйлчлэгч хөтөлж байна.

Сарын бүрийн 20-ний өдөр бүх нийтийн цэвэрлэгээг уурхайн нийт ажилчид, туслан гүйцэтгэгч компанийн ажилчдын хүчээр хийдэг. Мөн ахуйн болон аюултай хог хаягдлын бүртгэлийг тогтмол бүртгэж байна.

Хог хаягдлын ангилан ялгалтын цэгүүд

Хог хаягдлын төрлүүд	Байршиж буй газрын нэр	Солбилцол, Decimal degree	
Хаягдал тос хадгалах газар	Засварын газрын урд	108 56 34.458	46 5 50.729
Кемпийн түр хогийн цэг	Кемпээс өмнө зүгт 100 м-т	108 56 34.044	46 5 49.9
Хуучин дугуй хадгалах цэг	Засварын газрын хажууд	108 56 34.458	46 5 50.729
Хаягдал төмөр хадгалах газар	Засварын газрын зүүн хойд талд	108 56 33.133	46 5 49.988
Аккумулятор хадгалах газар	Засварын газарт	108 56 34.458	46 5 50.729

№	Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Биелэлт
1	Ахуйн	Орчны бохирдлоос сэргийлэх зорилгоор хог хаягдлыг ил хаяхгүй байх, тусгай тэмдэглэгээ бүхий хогийн саванд цуглуулах, хуваарьт цэвэрлэгээ хийх, хог тээвэрлэх зэрэг ажиллагааг уурхайн хэмжээнд мөрдөх тусгай журмаар хэрэгжүүлэх. Хур хог хаягдал үүсэхээс сэргийлэх,	100%
2		Уурхайн хэмжээнд гарах ахуйн хог хаягдлыг мэргэжлийн байгууллалатай гэрээ байгуулан тээвэрлэн устгалд оруулна.	100%
3	Үйлдвэрийн	Үйлдвэрээс гарах хог хаягдлын хэмжээг багасгах зорилгоор эх үүсвэр дээр нь ангилан ялгалт хийх.	100%
4		Уурхайн хэмжээнд гарах эргүүлэн ашиглах боломжтой хаягдлыг 100 хувь дахин ашиглах	100%
5	Аюултай	Аюултай хог хаягдалаас хөрсний бохирдол үүсэхээс сэргийлж зориулалтын байгууламжийг байгуулах	40%
6		Уурхайн хэмжээнд тогтмол гардаг тосны шүүр, арчих тослох материалаар бохирдсон материал, шингээгч, тос шингэсэн асгаралтын бүрдэл хуванцар тос, маслын сав баглаа боодлыг аюултай хог хаягдал зайлуулах, устгах мэргэжлийн байгууллагад нийлүүлнэ.	100%
7		Уурхайн яаралтай тусламжийн нэгж /эмнэлэгээс хэрэглэсэн тариур, тариарын зүү боолт гэх, мэт/ гарах хог хаягдлыг тусгай аюулгүйн хайрцагт цуглуулж тусгай зөвшөөрөлтэй байгууллагад нийлүүлнэ.	100%



Зураг 26. Амрах байрны өмнөх хогийн савнууд



Зураг 27. Кемпийн түр хогийн цэг



Зураг 28. Бүх нийтийн цэвэрлэгээ

УДИРДАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Төрийн байгууллагын төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус хяналт шалгалтанд тогтмол хамрагдаж илэрсэн зөрчил дутагдалыг арилгах арга хэмжээнүүдийг тогтмол хэрэгжүүлэн ажиллаж байна. Даланжаргалан сумын БО-ны асуудал хариуцсан мэргэжилтэн, байгаль хамгаалагч нараас мэргэжил арга зүйн туслалцаа аван хамтран ажиллаж байна. Орон нутгийн төрийн байгууллагуудаас зохион байгуулсан хурал, уулзалт, сургалт, семинарт компанийн холбогдох хүмүүс тогтмол оролцож байна.

Грийн сервис ХХК-иар БО-ны ээлжит аудитыг хийлгэхээр гэрээ байгуулан ажиллаж байна. 2023 оны 5-р сард Даланжаргалан сумын ЭМТөв уурхайн кемпт ариутгал халдваргүйжүүлэлт хийсэн.

2023 оны 6 дугаар сард уурхайн 44 ажилтныг эрүүл мэндийн үзлэгт хамруулсан.



Зураг 29. Ариутгал, халдваргүйжүүлэлт хийж байгаа нь



Зураг 30. Эрүүл мэндийн үзлэг

ОСОЛ, ЭРСДЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

№	Арга хэмжээ	Хэрэгжүүлэгч	Тайлбар	Биелэлт
1	Аваар устгах төлөвлөгөөг боловсруулж батлуулах	ХАБ-ын ажилтан	Зүүндалан, Далангийн уурхайн 2023 оны аваар устгах төлөвлөгөөг боловсруулж Уул уурхайн аврах ангийн удирдлагаар батлуулсан.	100 %
2	Осол, аюулыг бүртгэх	ХАБ-ын ажилтан	2023онд үйлдвэрлэлийн осол гараагүй. Осол дөхсөн тохиолдолуудыг бүртгэн зөрчлийг нэн даруй арилгах арга хэмжээ авч байна.	100 %
3	Ажилчдыг гэнэтийн ослын даатгалд хамруулах.	Уурхайн дарга, ХАБ-ын ажилтан	Даатгалын үйлчилгээ эрхэлдэг компаниудаас үнийн санал цуглуулж харьцуулалт хийж байна.	50 %
4	Гамшгаас хамгаалах төлөвлөгөө боловсруулж батлуулах	ХАБ-ын ажилтан	Зүүндалан, Далангийн уурхайн 2023 оны Гамшгаас хамгаалах төлөвлөгөөг боловсруулж Дорноговь аймгийн ОБГ-аараар батлуулан мөрдөн ажиллаж байна.	100 %
5	Ажлын байрны эрсдлийн үнэлгээ хийлгүүлэх	ХАБ-ын ажилтан	Мэргэжлийн байгууллага “Анлок Эдвайс” ХХК-иар ажлын байрны эрсдлийн үнэлгээг хийлгүүлсэн.	100 %

№	Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Биелэлт
1	Химийн хортой, аюултай бодис материалын хэрэглээ	Химийн хортой, аюултай нүүрсустөрөгчийн бодис материал ашиглагдах, талбайд химийн нийт бодисийн хор аюулын лавлах мэдээлэл буюу ХАЛМ-г бүрэн бүрдүүлж өөрийн компанийн ХАЛМ-ийн загварт орчуулан байрлуулана.	100%
2	Химийн бодисын хэрэглээг хянах	Химийн хортой, аюултай нүүрсустөрөгчийн бодис материалыг хадгалах, тээвэрлэх, ашиглах дотоод журмыг боловсруулан мөрдөж ажилчдад химийн хортой, аюултай бодис материалын талаар сургалт зааварчилгааг тогтмол явуулна.	100%

ОБЕГ-ын даргын 2018 оны 03 дугаар сарын 29-ны өдрийн А/75 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт

БАТЛАВ:
“БИЛЭГТ БАЯЛАГ” ХХК-ИЙН
ЗАХИРАЛ

Э.Хэнхзаяа
Э.ХЭНХЗАЯА

БИЛЭГТ БАЯЛАГ
ХХК
УЛААНБААТАР ХОТ

ЗӨВШӨӨРСӨН:
ОБЕГ-Н ДЭРГЭДЭХ УУЛ УУРХАЙН АВРАХ
АНГИЙН ЗАХИРАГЧ ХУРАНДАА

Д.Гантулга
Д.ГАНТУЛГА

8549114 ЦТА2005 5021210087

**“БИЛЭГТ БАЯЛАГ” ХХК-ИЙН НҮҮРСНИЙ УУРХАЙН
АЮУЛЫН ҮЕД ХЭРЭГЖҮҮЛЭХ ТӨЛӨВЛӨГӨӨ 2023**

Үндсэн АТЗ-ын дугаар: MV-021008

ХЯНАСАН:
УУЛ УУРХАЙН АВРАХ АНГИЙН АЛБАНЫ ДАРГА, АВРАХ АЖИЛЛАГААНЫ УДИРДАГЧ,
АХМАД: *Д.Баяржаргал* / Д.БАЯРЖАРГАЛ /

ХЯНАСАН:
“БИЛЭГТ БАЯЛАГ” ХХК-ИЙН
АШИГЛАЛТЫН ИНЖЕНЕР: *Б.Сандагдорж* / Б.САНДАГДОРЖ /

БОЛОВСРУУЛСАН:
“БИЛЭГТ БАЯЛАГ” ХХК-ИЙН
ХАБ-ЫН ИНЖЕНЕР: *Б.Мэнд* / Б.МЭНД /

Зураг 31. Аваар устгах төлөвлөгөөний нүүр

Батлав. “Билэгт Баялаг” ХХК-ийн
Гүйцэтгэх захирал *Энхзаяа* /Э.Энхзаяа/
2022 оны 10 сарын 31 өдөр



**ДОРНОГОВЬ АЙМГИЙН ДАЛАНЖАРГАЛАН
СУМЫН НУТАГТ ОРШИХ “ДАЛАН” НҮҮРСНИЙ
УУРХАЙН ГАМШГААС ХАМГААЛАХ 2023 ОНЫ
ТӨЛӨВЛӨГӨӨ**

MV-021008 ТООТ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛТЭЙ/

ХЯНАСАН:

ДОРНОГОВЬ АЙМГИЙН ОБ-ЫН ГАМШГААС ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨЛТ БЭЛЭН
БАЙДАЛ ХАРИУЦСАН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН, ГАМШГААС ХАМГААЛАХ
УЛСЫН ХЯНАЛТЫН БАЙЦААГЧ, АХМАД *Б.Батсүх* /Б.БАТСҮХ/



БОЛОВСРУУЛСАН:

“БИЛЭГТ БАЯЛАГ” ХХК

ХАБ-ЫН ИНЖЕНЕР *Мэнд* /Б.МЭНД/

Зураг 36. Гамшгаас хамгаалах төлөвлөгөөний нүүр

ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР

Агаарын шинжилгээ



**ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ГАЗАР
БАЙГАЛЬ ОРЧИН, ХЭМЖИЛ ЗҮЙН
ТӨВ ЛАБОРАТОРИ**

17043, Үйлдвэр 2-4, Чингисийн өргөн чөлөө гудамж,
Хан-Уул дүүрэг, 20-р хороо, Утас: 11-341818
E-mail: bohzt@gmail.com

СОРИЛТЫН ДҮН



Дугаар он/№ : 2023/А-06
 Дээжийг ирүүлсэн газрын нэр, хаяг, утас : “Билэгт Баялаг” ХХК
 Дээжийг авсан хүний нэр, албан тушаал : Б.Батхшиг агаарын хэсэг
 Дээжийн тоо, төрөл : 3 агаар, 3 дуу чимээ
 Сорьц авсан огноо : 2023.05.08
 Дээжийн тодорхойлолт : Дорноговь аймаг Даланжаргалан сум Элдэв баг
 Алаг толгой зүүн далангийн нүүрсний орд
 Шинжилгээний аргын стандарт : MNS 17.2.5.12:88, MNS 17.2.5.11:88, DUSTRAK8530
 Шинжилсэн огноо : 2023.05.08
 Хуудасны тоо : 1/1
 Үр дүн :

№	Сорьц авсан цэг	Сорьц авсан өдөр	Сорьц авсан цаг	Хүхэрлэг хий мг/м ³	Азотын давхар исэл мг/м ³	Нийт Тоос /TSP/ мг/м ³	Дуу чимээ /ДБА/
1	Карьер	V/06	14.20	0.024	0.022	0.240	35
2	Технологийн зам пүү орчим	V/06	14.50	0.015	0.027	0.170	45
3	Ажилчдын кемп	V/06	15.35	0.012	0.020	0.145	40
Агаарын чанарын стандарт MNS 4585:2016 (20 минутын хэмжилт)				0.450	0.200	0.500	60

Шинжилгээ гүйцэтгэсэн инженер:

Хянаж баталгаажуулсан:
Байгаль орчны шинжилгээний хэлтсийн дарга



Э.Оюунтуяа

Б.Бархасрагчаа

Хуулбарлан хэрэглэхийг хориглоно.
Сорилтын дүн нь зөвхөн шинжилсэн сорьцонд хүчинтэй

Хөрсний шинжилгээний хариу



ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ГАЗАР
БАЙГАЛЬ ОРЧИН, ХЭМЖИЛ ЗҮЙН
ТӨВ ЛАБОРАТОРИ

17043, Үйлдвэр 2-4, Чингисийн өргөн чөлөө гудамж,
Хан-Уул дүүрэг, 20-р хороо, Утас: 11-341818
E-mail: bohzi@gmail.com



СОРИЛТЫН ДҮН

Дугаар он/ № : 2023/ 124-125
 Дээжийг ирүүлсэн газрын нэр, хаяг, утас : “Билэгт баялаг” ХХК
 Дээжийг авсан хүний нэр, албан тушаал : Б.Батхишиг агаарын хэсэг
 Дээжийн тоо, төрөл : 2, хөрсний сорьц
 Хүлээн авсан огноо : 2023.05.08
 Дээжийн тодорхойлолт : Дорноговь аймаг Даланжаргалан сум
 Элдэв баг Зүүн далангийн нүүрсний уурхай
 Шинжилгээний аргын стандарт : САЗ А01:2022
 Шинжилсэн огноо : 2023.05.10
 Хуудасны тоо : 1/1
 Үр дүн:

№	Сорьц авсан цэгийн нэр	Кадьми (Cd)	Хар тугалга (Pb)	Мөнгөн ус (Hg)	Хром (Cr)	Цайр (Zn)	Зэс (Cu)	Стронци (Sr)
1	Ажилчдын кепт	0.8	14.6	<0.005	<0.005	9.0	29.2	236.8
2	Технологийн зам дагуу	<0.005	12.0	0.7	<0.005	42.0	28.8	194.0
MNS 5850:2019 / ЗД.Х/		3	100	2	150	300	100	800

Шинжилгээ гүйцэтгэсэн инженер :



Б.Даваасүрэн

Хянаж баталгаажуулсан

Байгаль Орчны Шинжилгээний хэлтсийн дарга,

Б.Бархасрагчаа

Хуулбарлан хэрэглэхийг хориглоно
Сорилтын дүн нь зөвхөн шинжилсэн дээжинд хүчинтэй

Хөрсний шинжилгээний хариу


**ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ГАЗАР
БАЙГАЛЬ ОРЧИН, ХЭМЖИЛ ЗҮЙН
ТӨВ ЛАБОРАТОРИ**

17043, Үйлдвэр 2-4, Чингисийн өргөн чөлөө гудамж,
Хан-Уул дүүрэг, 20-р хороо, Утас: 11-341818
E-mail: bohzt@gmail.com

СОРИЛТЫН ДҮН



Дугаар он/ № : 2023/126
 Дээжийг ирүүлсэн газрын нэр, хаяг, утас : “Билэгт баялаг” ХХК
 Дээжийг авсан хүний нэр, албан тушаал : Б.Батхшиг агаарын хэсэг
 Дээжийн тоо, төрөл : 1, хөрсний сорьц
 Хүлээн авсан огноо : 2023.05.08
 Дээжийн тодорхойлолт : Дорноговь аймаг Даланжаргалан сум
 Элдэв баг Зүүн далангийн нүүрсний уурхай
 Шинжилгээний аргын стандарт : MNS 3310:1991
 Шинжилсэн огноо : 2023.05.11
 Хуудасны тоо : 1/1
 Үр дүн:

№	Сорьц авсан цэг	Чийг %	pH	Ялзмаг %	Аммоны азот (NH ₄ -N) мг/кг	Нитратын азот (NO ₃ -N) мг/кг	Фосфор (P ₂ O ₅) мг/кг	Сульфат (SO ₄) мг/кг
1	Шимт овоолго	1.01	7.5	0.41	10.1	16.0	16.2	21.0

Шинжилгээ гүйцэтгэсэн техникч : *Н.Эрдэнэсүрэн*

Хянаж баталгаажуулсан

Байгаль Орчны Шинжилгээний хэлтсийн дарга : *Б.Бархасрагчаа*



Н.Эрдэнэсүрэн

Б.Бархасрагчаа

Хуулбарлан хэрэглэхийг хориглоно
Сорилтын дүн нь зөвхөн шинжилсэн дээжинд хүчинтэй

Хөрсний шинжилгээний хариу


**ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ГАЗАР
БАЙГАЛЬ ОРЧИН, ХЭМЖИЛ ЗҮЙН
ТӨВ ЛАБОРАТОРИ**

17043, Үйлдвэр 2-4, Чингисийн өргөн чөлөө гудамж,
Хан-Уул дүүрэг, 20-р хороо, Утас: 11-341818
E-mail: bohzt@gmail.com

**СОРИЛТЫН ДҮН**

Дугаар он/ № : 2023/ 124-125
 Дээжийг ирүүлсэн газрын нэр, хаяг, утас : “Билэгт баялаг” ХХК
 Дээжийг авсан хүний нэр, албан тушаал : Б.Батхшиг агаарын хэсэг
 Дээжийн тоо, төрөл : 2, хөрсний сорьц
 Хүлээн авсан огноо : 2023.05.08
 Дээжийн тодорхойлолт : Дорноговь аймаг Даланжаргалан сум
 Элдэв баг Зүүн далангийн нүүрсний уурхай
 Шинжилгээний аргын стандарт : САЗ А01:2022
 Шинжилсэн огноо : 2023.05.10
 Хуудасны тоо : 1/1
 Үр дүн:

№	Сорьц авсан цэгийн нэр	Кадьми (Cd)	Хар тугалга (Pb)	Мөнгөн ус (Hg)	Хром (Cr)	Цайр (Zn)	Зэс (Cu)	Стронци (Sr)
1	Ажилчдын кемп	0.8	14.6	<0.005	<0.005	9.0	29.2	236.8
2	Технологийн зам дагуу	<0.005	12.0	0.7	<0.005	42.0	28.8	194.0
	MNS 5850:2019 / ЗДХ/	3	100	2	150	300	100	800

Шинжилгээ гүйцэтгэсэн инженер :



Б.Даваасүрэн

Хянаж баталгаажуулсан

Байгаль Орчны Шинжилгээний хэлтсийн дарга

Б.Бархасрагчаа

Хуулбарлан хэрэглэхийг хориглоно
Сорилтын дүн нь зөвхөн шинжилсэн дээжинд хүчинтэй

Хөрсний шинжилгээний хариу


**ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ГАЗАР
БАЙГАЛЬ ОРЧИН, ХЭМЖИЛ ЗҮЙН
ТӨВ ЛАБОРАТОРИ**

17043, Үйлдвэр 2-4, Чингисийн өргөн чөлөө гудамж,
Хан-Уул дүүрэг, 20-о хороо, Утас: 11-341618
E-mail: botztl@gmail.com

СОРИЛТЫН ДҮН



Дугаар он/ № : 2023/126
 Дээжийг ирүүлсэн газрын нэр, хаяг, утас : “Билэгт баялаг” ХХК
 Дээжийг авсан хүний нэр, албан тушаал : Б.Батхишиг агаарын хэсэг
 Дээжийн тоо, төрөл : 1, хөрсний сорьц
 Хүлээн авсан огноо : 2023.05.08
 Дээжийн тодорхойлолт : Дорноговь аймаг Даланжаргалан сум
 Элдэв баг Зүүн далангийн нүүрсний уурхай
 Шинжилгээний аргын стандарт : MNS 3310:1991
 Шинжилсэн огноо : 2023.05.11
 Хуудасны тоо : 1/1
 Үр дүн:

№	Сорьц авсан цэг	Чийг %	pH	Ялзмаг %	Аммоны азот (NH ₄ -N) мг/кг	Нитратын азот (NO ₃ -N) мг/кг	Фосфор (P ₂ O ₅) мг/кг	Сульфат (SO ₄) мг/кг
1	Шимт өвөөлгө	1.01	7.5	0.41	10.1	16.0	16.2	21.0

Шинжилгээ гүйцэтгэсэн техникч : *Н.Эрдэнэсүрэн*

Хянаж баталгаажуулсан

Байгаль Орчны Шинжилгээний халтсийн дарга : *Б.Бархасрагчаа*



Н.Эрдэнэсүрэн

Б.Бархасрагчаа

Хуулбарлан хэрэглэхийг хориглоно
Сорилтын дүн нь зөвхөн шинжилсэн дээжинд хүчинтэй

Усны шинжилгээний хариу


**ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ГАЗАР
БАЙГАЛЬ ОРЧИН, ХЭМЖИЛ ЗҮЙН
ТӨВ ЛАБОРАТОРИ**

17043, Үйлдвэр 2-4, Чингисийн өргөн чөлөө гудамж,
Хан-Уул дүүрэг, 20-р хороо, Утас: 11-341818
E-mail: bohztla@gmail.com

**СОРИЛТЫН ДҮН**

Дугаар он/№	: 2023/ Ц-52
Сорьцыг ирүүлсэн газрын нэр, хаяг, утас	: “Билэгт Баялаг” ХХК
Сорьцыг авсан хүний нэр, албан тушаал	: Б.Батхшиг, БОХЗТЛ
Сорьцын тоо, төрөл	: 1, ус
Сорьцыг авсан огноо	: 2023.05.06
Сорьцын тодорхойлолт	: Усны сорьц
Шинжилгээний аргын стандарт	MNS ISO 10523:2001, MNS ISO 7888:1999, MNS 6271:2011, MNS 4424:2005 MNS 1097:1970, MNS 6832:2020
Шинжилсэн огноо	: 2023.05.07-2023.05.23
Хуудасны тоо	: 2 / 2
Үр дүн	: 1

Сорьцын нэр	pH	EC мкСм/см	SO ₄ мг/л	Cl мг/л	Ca мг/л	Mg мг/л	Na+K мг/л	HCO ₃ мг/л	Эрд мг/л	Хат мг-экв/л
Дорноговь аймаг Даланжаргалан сум Элдэв баг Гүний худаг	8.34	1499	447	88.6	84.2	120	169	549	1458	14.06
MNS 0900:2018	6.5-8.5	1000	500	350	100	30	-	-	-	7.0

Тайлбар: EC - цахилгаан дамжуулах чанар, Хат-Хатуулаг, Эрд-Эрдэсжилт

Шинжилгээ гүйцэтгэсэн инженер:

Шалгасан инженер:

Хянаж баталгаажуулсан инженер:



Хуулбарлан хэрэглэхийг хориглоно.
Сорилтын дүн нь зөвхөн шинжилсэн сорьцонд хүчинтэй.

Усны шинжилгээ бохир ус


**ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ГАЗАР
БАЙГАЛЬ ОРЧИН, ХЭМЖИЛ ЗҮЙН
ТӨВ ЛАБОРАТОРИ**

17043, Үйлдвэр 2-4, Чингисийн ергэн чөлөө гудамж,
Хан-Уул дүүрэг, 20-р хороо, Утас: 11-341818
E-mail: bohzt@gmail.com

СОРИЛТЫН ДҮН

Дугаар он/№	: 2023 / Б-50
Сорьцыг ирүүлсэн газрын нэр, хаяг, утас	: “Билэгт Баялаг” ХХК
Сорьцыг авсан хүний нэр, албан тушаал	: Б.Батхшиг, БОХЗТЛ
Сорьцын тоо, төрөл	: 2, Бохир ус
Сорьцыг авсан огноо	: 2023.05.06
Сорьцын тодорхойлолт	: Бохир усны сорьц
Шинжилгээний аргын стандарт	: MNS ISO 10523:2001, MNS 6836 :2020 MNS ISO 6060:2001, MNS ISO 7150-1:2006 MNS 4431:2005, MNS ISO 7890-3:2001 MNS ISO 6878:2001
Шинжилсэн огноо	: 2023.05.07-2023.05.23
Хуудасны тоо	: 1 /1
Үр дүн	: 2

Сорьцын авсан цэг	pH	ЖБ мг/л	XXX мг/л	NH ₄ -N мг/л	NO ₂ -N мг/л	NO ₃ -N мг/л	N _{total} мг/л	P _{total} мг/л
Дорноговь аймаг Даланжаргалан сум Гаргалгаа	7.12	113	661	0.80	0.057	0.15	1.01	0.100
MNS 4943:2015	6-9	30	50	-	-	-	15	1.5

Тайлбар: ЖБ- Жиелэгдэлч бодис, XXX- Химийн Хэрэгцээт Хүчилтөрөгч

Шинжилгээ хийсэн инженер:

Шалгасан инженер:

Хянаж баталгаажуулсан инженер:

Ц.Мийдүв

С.Отгонжаргал

Б.Алтантуяа



Хуулбарлан хэрэглэхийг хориглоно.
Сорилтын дүн нь зөвхөн шинжилсэн сорьцонд хүчинтэй.

Усны шинжилгээ


**ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ГАЗАР
БАЙГАЛЬ ОРЧИН, ХЭМЖИЛ ЗҮЙН
ТӨВ ЛАБОРАТОРИ**

17043, Үйлдвэр 2-4, Чингисийн өргөн чөлөө гудамж,
Хан-Уул дүүрэг, 20-р хороо, Утас: 11-341818
E-mail: bohzt@gmail.com

**СОРИЛТЫН ДҮН**

Дугаар он/№	: 2023/ Ц-52
Сорьцыг ирүүлсэн газрын нэр, хаяг, утас	: “Билэгт Баялаг” ХХК
Сорьцыг авсан хүний нэр, албан тушаал	: Б.Батхшиг, БОХЗТЛ
Сорьцын тоо, төрөл	: 1, ус
Сорьцыг авсан огноо	: 2023.05.06
Сорьцын тодорхойлолт	: Усны сорьц
Шинжилгээний аргын стандарт	MNS ISO 6836:2020, MNS ISO 8467:1999 MNS ISO 7150-1:2006, MNS 4431:2005 MNS 7890-3:2001, MNS ISO 6878:2001 MNS 4430:2005, MNS 6272: 2011
Шинжилсэн огноо	: 2023.05.07-2023.05.23
Хуудасны тоо	: 1 /2
Үр дүн	: 1

Сорьцын нэр	Ж/б мг/л	ПИЧ мг/л	NH ₄ мгN/л	NO ₂ мгN/л	NO ₃ мгN/л	PO ₄ мгP/л	Fe мг/л	F мг/л
Дорноговь аймаг Даланжаргалан сум Элдэв баг Гүний худаг	1.2	1.0	0.04	0.003	1.28	0.003	илр	0.84
MNS 0900:2018	-	-	1.5	1.0	50	3.5	0.3	0.7-1.5

Тайлбар: Ж/б-Жинлэгдсэн бодис, ПИЧ-Перманганатын Исэлдэх Чанар, Илр-Илрээгүй

Шинжилгээ гүйцэтгэсэн инженер:  Ц.Мийдүв
Шалгасан инженер:  С.Отгонжаргал
Хянаж баталгаажуулсан инженер:  Б.Алтантуяа



Хуулбарлан хэрэглэхийг хориглоно.
Сорилтын дүн нь зөвхөн шинжилсэн сорьцонд хүчинтэй.

Усны шинжилгээ



ЗАСГИЙН ГАЗРЫН
ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
УСНЫ ГАЗАР

ХЯНАЛТЫН ТӨВ ЛАБОРАТОРИ
/Central inspection laboratory/

Төвхөнхотгор хот, Баянхот дүүрэг, 2-дугаар
төвхөнхотгор туслах тал, УТ90023

ИТГЭМЖЛЭГДСЭН ЛАБОРАТОРИЙН
СОРИЛТЫН ДҮНГИЙН ХУУДАС
/ Test result of accredited laboratory /



TL 092
MNS ISO 17025

Захиалагчийн нэр / Customer name /: “Билэгт Баялаг” ХХК

Шинжилгээний тодорхойлолт /Analysis type/	Дээжний дугаар /Test number/	Дээжний хаяг, байршил /Sample location/	Уст цэгийн төрөл /Type of water/	
Цэвэр усны хими	№ 614	Даланкаргалан сум, 1-р баг, Шар шороот, Малчдын худаг	Гүний худаг	46°08'01.8" 108°53'44.4"

Дээжний хэмжээ /Quantity of sample/	Дээж хүлээн авсан огноо /Receiving date/	Шинжилсэн огноо /Analyzing date/	Хэвлэсэн огноо /Printed date/	Техникийн шаардлага /Technical requirements/
2.0л / 2.0l	2023.05.25	2023.05.25-06.12	2023.06.12	MNS 0900:2018

№	Үзүүлэлт /Parameters/	Шинжилэх аргын стандарт /Test method/	Зөвшөөрөгдөх дээд хэмжээ /Technical specification/	Үр дүн / Test result/
1	pH-Усны орчин /Hydrogen ions/	MNS ISO 10523-2001	6.5-8.5	8.01
2	Цахилгаан дамжуулах чанар, мСм/см /Electrical conductivity/	MNS ISO 7888:1999	<1.0	2.02
3	Ерөнхий хатуулаг, мг-экв/л /Total hardness, mg-eq/L/	MNS ISO 6059:2005	<7.0	9.00
4	Кальци, (Ca ²⁺) мг/л /Calcium ion, mg/L/	MNS 1097:1970	<100.0	56.11
5	Магни, (Mg ²⁺) мг/л /Magnesium ion, mg/L/	MNS 1097:1970	<30.0	75.39
6	Карбонат, (CO ₃ ⁻) мг/л /Carbonate ion, mg/L/	MNS ISO 9963-1:2005	-	0.00
7	Хлорид, (Cl ⁻) мг/л /Chloride ion, mg/L/	MNS ISO 9297:2005	<350.0	255.24
8	Гидрокарбонат, (HCO ₃ ⁻) мг/л /Hydrocarbon ion, mg/L/	MNS ISO 9963-1:2005	-	396.50
9	Нитрит, (NO ₂ ⁻) мг/л /Nitrite ion, mg/L/	MNS 4431-2005	<1.0	0.02
10	Нитрат, (NO ₃ ⁻) мг/л /Nitrate ion, mg/L/	MNS ISO 7890-3:2001	<50.0	101.00
